



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 11/163

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны талаар  
авах зарим арга хэмжээний тухай

Авлига албан тушаалын гэмт хэрэг болон ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн хөрөнгөөр болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөгөөс дээш хөрөнгөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг Эрүүл мэнд, спортын яам болон олон улсын санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн нэгжүүдэд хориглосугай.

2. Төрийн өмчийн хөрөнгөөр болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсүгэй.

3. Эрүүл мэнд, спортын салбарт хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техинкийн тодорхойлолт, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн худалдан авах ажиллагааг яаралтай зохион байгуулах, энэхүү тушаалын хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэнд спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа/-д үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080577